



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛЫН ЯАМ**

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200  
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,  
Цахим шуудан: letter@moe.gov.mn,  
Цахим хуудас: www.moe.gov.mn

2025.04.21 № 3/1641

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Чиглэл хүргүүлэх тухай**

Боловсролын ерөнхий хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан Насан туршийн суралцахуйн бодлого, тэргүүлэх чиглэлд нийцүүлэн Насан туршийн суралцахуйн төвийн “Орон тооны хязгаарын жишиг норматив”-г Боловсролын сайд, Сангийн сайдын 2025 оны А135/А68 дугаар хамтарсан тушаалаар, “Насан туршийн суралцахуйн төвийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-ийг Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2025 оны А/136А/80А/69 дүгээр хамтарсан тушаалаар батлуулсныг үүгээр хүргүүлж байна.

“Орон тооны хязгаарын жишиг норматив”-г боловсруулахдаа хүн амын тоо, үйлчлэх хүрээ, суралцагчдын тоон мэдээллийг харгалзан тухайн орон нутгийн онцлогт нийцүүлэн боловсруулж, төвүүдээс санал авч тусгасан болно. Насан туршийн суралцахуйн төвийн сургалтын менежер, албан бус боловсролын багшийн албан тушаалын үлгэрчилсэн чиг үүргийг хавсралтад заасны дагуу албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж батлан хэрэгжүүлнэ үү.

Хавсралт ... хуудастай.

**БОЛОВСРОЛЫН НЭГДСЭН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН  
ДАРГА**

**П.ОЮУНАА**



14259 1676

**БОЛОВСРОЛЫН САЙД, ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2025 оны ~~01~~ сарын ~~02~~-ны өдөр

Дугаар ~~А/36~~ ~~А/20~~ ~~А/19~~ Улаанбаатар хот


**Шалгуур үзүүлэлт батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 4 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Насан туршийн суралцахуйн төвийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийг хавсралтаар баталсугай.


2. Шалгуур үзүүлэлтийн дагуу тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд ур чадварын нэмэгдлийг цалингийн санд багтаан албан хаагчдад олгохыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.

**БОЛОВСРОЛЫН  
САЙД**




**П.НАРАНБАЯР**

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД**




**Л.ЭНХ-АМГАЛАН**

**САНГИЙН  
САЙД**



**Б.ЖАВХЛАН**



## НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН АЛБАН ХААГЧДАД УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1.Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлд хамаарах аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн төв (цаашид "Төв" гэх)-ийн ийн захирал, сургалтын менежер, албан бус боловсролын багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч (цаашид "албан хаагч" гэх) нарт ур чадварын нэмэгдэл олгоход энэхүү шалгуур үзүүлэлтийг мөрдөнө.

2.Ур чадварын нэмэгдэл олгоходоо албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн, шинэ санаачилга дэвшүүлж, туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлсэн албан хаагчдад энэхүү баримт бичгийн 5, 6, 7-д заасан шалгуур үзүүлэлтийг баримтална.

3.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага төвийн захирлыг, төвийн захирал нь албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох, үнэлэх ажлын хэсэг байгуулан энэхүү шалгуур үзүүлэлтийн 7-д заасан тусгай шалгуурыг баримтлан нарийвчлан боловсруулан үнэлж, дүгнэж болно.

4.Энэхүү журмын 3-т заасан ажлын хэсэг нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцуулж болно.

5.Төвийн захиралд ур чадварын нэмэгдэл олгоход дараах нийтлэг шалгуурыг харгалзана. Үүнд:

- 5.1.төсвийн төвлөрүүлэн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээний биелэлт нь "Хангалттай" түвшинд үнэлэгдсэн байх;
- 5.2.ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэл хүлээгээгүй байх;
- 5.3.авлига албан тушаалын болон санхүүгийн зөрчилгүй байх;

6.Төвийн сургалтын менежер, албан бус боловсролын багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид ур чадварын нэмэгдэл олгоход дараах нийтлэг шалгуурыг харгалзана. Үүнд:

- 6.1.төсвийн шууд захирагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний биелэлт "Хангалттай" түвшинд үнэлэгдсэн байх;
- 6.2.ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэл хүлээгээгүй байх;
- 6.3.төвийн орчинд хүний эрхийн зөрчил гараагүй байх;

7.Энэхүү шалгуур үзүүлэлтийн 5, 6-д заасан нийтлэг шалгуурыг хангасан албан хаагчдын ажлыг дараах тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу тус тус үнэлнэ.

### 7.1. Төвийн захирал

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Удирдан зохион байгуулах	Мэдлэг боловсролоо дээшлүүлж, хүний нөөцийн тасралтгүй хөгжил, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжсэн байх	25
Дүн шинжилгээ хийх	Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, судалгааны арга зүйг эзэмшиж, ажилдаа үр дүнтэй хэрэгжүүлдэг байх	25
Хамтын ажиллагаа	Нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагад тулгуурлан түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлсэн байх	25
Инновацийн сэтгэлгээ, технологийн мэдлэг	Технологийн дэвшлийг ашиглан сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах, шинэлэг санаа, арга барилыг нэвтрүүлдэг байх	25

### 7.2. Төвийн сургалтын менежер

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Манлайлал	Мэргэжлээрээ тасралтгүй хөгжиж, туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлдэг байх	25
Мэргэжлийн ур чадвар	Орчин үеийн сургалтын технологи, материалыг ашиглах чадвартай байх	25
	Суралцагчдын ялгаатай хэрэгцээ, чадварт тохируулан сургалтын зохицуулалтыг оновчтой удирдан зохион байгуулдаг байх	25
Багаар ажиллах	Иргэдийн сурч хөгжих хэрэгцээ, хөдөлмөр эрхлэх ур чадварын судалгаа хийж, үр дүнд үндэслэн бусад оролцогч талуудтай хамтран ажилласан байх	25

### 7.3. Төвийн албан бус боловсролын багш

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Манлайлах ур чадвар	Мэргэжлээрээ тасралтгүй хөгжин, мэдлэг ур чадвар, туршлагаа бусад багш нарт түгээн дэлгэрүүлдэг байх	20
Мэргэжлийн ур чадвар	Суралцагчдын хөгжлийн онцлог, сонирхол хэрэгцээг танин мэдэж түүнд тохирсон сургалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх арга зүйн чадвартай байх	20
Багаар ажиллах	Иргэдэд боловсролын үйлчилгээ хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажилладаг байх	30

	Иргэдийн сурч хөгжих хэрэгцээ, сонирхлын судалгаа хийх, үр дүнд үндэслэн боловсрол, сургалтын болон бусад үйлчилгээг зохион байгуулдаг байх	30
--	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----

#### 7.4. Төвийн нийгмийн ажилтан

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Манлайлах ур чадвар	Төвийн орчинд сэтгэл зүйн таатай орчин, зэрэг уур амьсгал бүрдүүлж, харилцааны зөв дадал хэвшил төлөвшүүлэх чиглэлээр, багш, ажилтныг манлайлан ажилладаг байх	30
Мэргэжлийн ур чадвар	Мэргэжлээрээ тасралтгүй хөгжин, мэдлэг чадвараа нэмэгдүүлж идэвх санаачилгатай ажилладаг байх	30
	Иргэдийн хөгжлийн онцлог, ялгаатай байдалд тохирсон урьдчилан сэргийлэх үйлчилгээний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлдэг байх	40

#### 7.5. Төвийн сэтгэл зүйч

Шалгуур	Үзүүлэлт	Нийт үнэлгээнд эзлэх хувь
Манлайлах ур чадвар	Иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлж, төвд зэрэг хандлагыг түгээн дэлгэрүүлдэг байх	40
Мэргэжлийн ур чадвар	Мэргэжлээрээ тасралтгүй хөгжиж идэвх санаачилгатай ажилладаг байх	30
	Иргэдэд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих чиглэлээр сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулдаг байх	30

8. Албан хаагчийн ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.

9. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60-аас дээш оноо авсан албан хаагчдад тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдлийг дараах аргачлалаар тооцож олгоно. Үүнд:

- 60 оноо авбал ур чадварын нэмэгдлийг 10%
- 61-75 оноо авбал ур чадварын нэмэгдлийг 11-15%
- 76-85 оноо авбал ур чадварын нэмэгдлийг 16-20%
- 86-100 оноо авбал ур чадварын нэмэгдлийг 21-25%

10. Энэхүү шалгуур үзүүлэлтийн 3-т заасан ажлын хэсгийн санал, дүгнэлтэд үндэслэн төвийн захиралд ур чадварын нэмэгдэл олгохыг боловсролын асуудал

хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар, төвийн албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг төвийн захирлын тушаалаар тус тус олгоно.

11. Албан хаагчдын ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга, хамт олны оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

12. Ур чадварын нэмэгдлийг тухайн албан хаагчдын манлайлал, мэргэжлийн ур чадвараас өөр хүчин зүйл (эрүүл мэнд, амьдрал, ахуйн нөхцөл, байдал)-ийг харгалзан олгохгүй.

13. Төвийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохтой холбоотой гомдол саналыг төвийн захирал, удирдах албан тушаалын гомдлыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хянан үзэж өргөдөл гомдлын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

## БОЛОВСРОЛЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар АБС/АБС

Улаанбаатар хот

### Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалт, Монгол Улсын Их хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын 1.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн орон тооны хязгаарын жишиг нормативыг нэгдүгээр хавсралтаар, Аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн орон тооны хязгаарын жишиг нормативыг мөрдөх зааврыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг арга зүйн удирдлагаар хангаж, жил бүрийн батлагдсан төсөвт багтаан орон тооны хязгаарын жишиг нормативын хэрэгжилтийг хангах, холбогдох зардлыг төсөвт тусган ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), хяналт тавьж ажиллахыг Боловсролын яамны Салбарын хяналтын газар (Л.Төгсбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Орон тооны хязгаарын жишиг норматив батлагдсантай холбогдуулан тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын төсвийг үр ашигтай зарцуулах, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Насан туршийн суралцахуйн төвийн захирал нарт даалгасугай.


4. Энэхүү тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

БОЛОВСРОЛЫН САЙД



САНГИЙН САЙД





**Нэг. Аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн орон тооны хязгаарын жишиг норматив**

№	Албан тушаалын жагсаалт	Хүн амын тоо (мянга)		
		75 хүртэлх	75-108 хүртэлх	108-аас дээш
1	Захирал	1	1	1
2	Сургалтын менежер	3	3	4+(2)***
3	Албан бус боловсролын багш	2+(1)*	3+(5)**	3+(3)***
4	Ерөнхий нягтлан бодогч	1	1	1
5	Бусад (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч)	1+(1)*	1+(1)**	1+(2)***
6	Төрийн үйлчилгээний гүйцэтгэх албан тушаал (ТҮ-1, ТҮ-2, ТҮ-3)	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулах		

**Тайлбар:**


- \*Говь-Алтай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн (75 мянга хүртэлх хүн амтай) үйлчлэх хүрээг харгалзан захирал 1, сургалтын менежер 3, албан бус боловсролын багш 3, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 2; (Тушаалын 2 дугаар хэвсрэлтын 2.3.1)
- \*\*Увс аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн (108 мянга хүртэлх хүн амтай) үйлчлэх хүрээг харгалзан захирал 1, сургалтын менежер 3, албан бус боловсролын багш 8, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 2; (Тушаалын 2 дугаар хэвсрэлтын 2.3.2)
- \*\*\*Ховд аймгийн Насан туршийн суралцахуйн төв нь (108 мянга хүртэлх хүн амтай) орон нутгийн онцлог, салбар төв, үйлчлэх хүрээг харгалзан захирал 1, сургалтын менежер 6, албан бус боловсролын багш 8, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 3; (Тушаалын 2 дугаар хэвсрэлтын 2.3.3)
- \*\*\*\*Дархан, Орхон аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн (108 мянгаас дээш хүн амтай) хот суурин газар, үйлчлэх хүрээг харгалзан захирал 1, сургалтын менежер 6, албан бус боловсролын багш 6, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 2; (Тушаалын 2 дугаар хэвсрэлтын 2.3.4)

**Хоёр. Дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн орон тооны хязгаарын жишиг норматив**

№	Албан тушаалын жагсаалт	Хүн амын тоо (мянга)				
		5 хүртэлх	5-100 хүртэлх	100-260 хүртэлх	260-360 хүртэлх	360-с дээш
1	Захирал	1	1	1	1	1
2	Сургалтын менежер	1	6+(1)*****	7	7	8
3	Албан бус боловсролын багш	2	5	5	6	7
4	Ерөнхий нягтлан бодогч	1	1	1	1	1
5	Бусад (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч)	-	2	2	3	3
6	Төрийн үйлчилгээний гүйцэтгэх албан тушаал (ТҮ-1, ТҮ-2, ТҮ-3)	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулах				

**Тайлбар:**

- \*\*\*\*\*Багануур дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн (100 мянга хүртэлх хүн амтай) стандартын шаардлага хангасан жишиг байр, хүчин чадлыг харгалзан захирал 1, сургалтын менежер 7, албан бус боловсролын багш 5, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 2; (Тушаалын 2 дугаар хэвсрэлтын 2.3.5)



## Аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн орон тооны хязгаарын жишиг нормативыг мөрдөх заавар

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн төв (цаашид "төв" гэх) энэхүү орон тооны хязгаарын жишиг нормативыг баримтална.

1.2. Орон тооны хязгаарын жишиг нормативыг мөрдөхдөө төвийн зохион байгуулалтын бүтэц, барилга байгууламжийн хүчин чадал, хүн амын тоо, үйлчлэх хүрээ зэрэг холбогдох бусад асуудлыг харгалзан орон тооны хязгаарын жишиг нормативд багтаан ялгавартай хэрэглэж болно.

### Хоёр. Орон тооны хязгаарын жишиг нормативыг тооцох

2.1. Аймгийн төвийн орон тооны хязгаарын жишиг нормативыг хүн амын тоо, орон нутгийн онцлог, үйлчлэх хүрээгээс хамааран дараах байдлаар тогтооно.

2.1.1. 75 мянга хүртэлх хүн амтай бол захирал 1, сургалтын менежер 3, албан бус боловсролын багш 2, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 1;

2.1.2. 75-108 мянга хүртэлх хүн амтай бол захирал 1, сургалтын менежер 3, албан бус боловсролын багш 3, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 1;

2.1.3. 108 мянгаас дээш хүн амтай бол захирал 1, сургалтын менежер 4, албан бус боловсролын багш 3, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 1;

2.2. Дүүргийн төвийн орон тооны хязгаарын жишиг нормативыг хүн амын тоо, орон нутгийн онцлог, үйлчлэх хүрээгээс хамааран дараах байдлаар тогтооно.

2.2.1. 5 мянга хүртэлх хүн амтай бол захирал 1, сургалтын менежер 1, албан бус боловсролын багш 2, ерөнхий нягтлан бодогч 1;

2.2.2. 5-100 мянга хүртэлх хүн амтай бол захирал 1 сургалтын менежер 6, албан бус боловсролын багш 5; ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 2;

2.2.3. 100-260 мянга хүртэлх хүн амтай бол захирал 1, сургалтын менежер 7, албан бус боловсролын багш 5, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 2;

2.2.4. 260-360 мянга хүртэлх хүн амтай бол захирал 1, сургалтын менежер 7, албан бус боловсролын багш 6, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 3;

2.2.5. 360 мянгаас дээш хүн амтай бол захирал 1, сургалтын менежер 8, албан бус боловсролын багшийг 7, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 3;

2.3. Зарим аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн хамрах хүрээ, үйл ажиллагааны онцлогоос хамааран орон тооны хязгаарын жишиг нормативыг дараах төвүүдэд ялгаатай хэрэглэнэ.

2.3.1. \*Говь-Алтай аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн (75 мянга хүртэлх хүн амтай) үйлчлэх хүрээг харгалзан захирал 1, сургалтын менежер 3,

албан бус боловсролын багш 3, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 2;

2.3.2.\*\*Увс аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн (108 мянга хүртэлх хүн амтай) үйлчлэх хүрээг харгалзан захирал 1, сургалтын менежер 3, албан бус боловсролын багш 8, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 2;

2.3.3.\*\*\*Ховд аймгийн Насан туршийн суралцахуйн төв нь (108 мянга хүртэлх хүн амтай) салбар төв, үйлчлэх хүрээг харгалзан захирал 1, сургалтын менежер 6, албан бус боловсролын багш 6, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 3;

2.3.4.\*\*\*\*Дархан, Орхон аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн (108 мянгаас дээш хүн амтай) хот суурин газар, үйлчлэх хүрээг харгалзан захирал 1, сургалтын менежер 6, албан бус боловсролын багш 6, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 2;

2.3.5.\*\*\*\*\*Багануур дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн (100 мянга хүртэлх хүн амтай) стандартын шаардлага хангасан жишиг байр, хүчин чадлыг харгалзан захирал 1, сургалтын менежер 7, албан бус боловсролын багш 5, ерөнхий нягтлан бодогч 1, бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч) 2;

### **Гурав. Бусад**

3.1.Бусад албан тушаал (нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, архив бичиг хэргийн эрхлэгч, зохион байгуулагч)-ын орон тоог давхардуулан ажиллуулахгүй бөгөөд үйл ажиллагааны онцлогт тохируулан жишиг нормативд багтаан ажиллуулж болно.

3.2.Төвийн жижүүр, манаач, мужаан, сантехникч, цахилгаанчин, үйлчлэгч нарыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд холбогдох хуульд зааснаар зохицуулан ажиллуулна.

**НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН СУРГАЛТЫН МЕНЕЖЕР БОЛОН  
АЛБАН БУС БОЛОВСРОЛЫН БАГШИЙН ОРОН ТОО**

№	Албан тушаалын ангилал	Зорилго	Зорилт
1	<b>Менежерийн албан тушаал</b>		
1.1	Байгууллагын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан сургалтын менежер	Насан туршийн суралцахуйн бодлогын хэрэгжилтийг тухайн орон нутгийн онцлогт нийцүүлэн төвийн үйл ажиллагаанд төлөвлөн хэрэгжүүлэх, холбогдох мэдээ, тайланг цаг хугацаанд нь үр дүнд суурилсан байдлаар тайлагнах, бусад менежер болон албан бус боловсролын багш, ажилтны ажлын уялдаа холбоог нэмэгдүүлэх, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх	<p>1.Насан туршийн суралцахуйн бодлогыг төвийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн алсын хараа, байгууллагын төлөвлөгөөг боловсруулна.</p> <p>2.Төвийн үйл ажиллагаатай холбогдох мэдээ тайланг үр дүнд суурилсан байдлаар цаг хугацаанд нь нэгтгэн тайлагнана.</p> <p>3.Гадаад болон дотоодын байгууллагуудтай насан туршийн суралцахуйн бодлогын хүрээнд хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, байгууллагын гадаад харилцааг өргөжүүлнэ.</p> <p>4.Иргэдийн боловсролд хамрагдалт, бусад ур чадварын тандалт судалгааг орон нутгийн байгууллагатай хамтран 3 жил тутамд нэг удаа хийх, мэдээллийн сан бүрдүүлж нэгдсэн арга зүйгээр хангана.</p> <p>5.Төвийн дотоод ажил болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>
1.2	Боловсрол нөхөн олгох сургалтын менежер	Иргэдийн бичиг үсгийн боловсрол болон боловсролд хамрагдалтын тандалт судалгааг орон нутгийн байгууллагатай хамтран 3 жил тутамд нэг удаа хийж, мэдээллийн сан бүрдүүлэх, бичиг үсгийн боловсрол болон боловсрол нөхөн эзэмших төлөвлөгөөг боловсруулах, холбогдох боловсролын сургалтын байгууллагатай хамтран иргэдэд бичиг үсгийн боловсрол олгох, боловсрол нөхөн эзэмшүүлэх	<p>1.Иргэдэд бичиг үсгийн болон боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайлагнах, багшийг арга зүй удирдлагаар хангана.</p> <p>2.Боловсролд хамрагдалтын тандалт судалгааг орон нутгийн байгууллагатай хамтран 3 жил тутамд нэг удаа хийж мэдээллийн сан бүрдүүлэх</p> <p>3.Холбогдох боловсрол сургалтын байгууллагуудтай хамтран ажиллана.</p> <p>4.Холбогдох мэдээ тайланг үр дүнд суурилсан байдлаар цаг хугацаанд нь тайлагнана.</p> <p>5.Төвийн дотоод ажил болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>

1.3	Хувь хүний хөгжил хариуцсан сургалтын менежер	Иргэдийн насан туршдаа суалцахууд дэмжлэг үзүүлж хувь хүний ур чадвар нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	<p>1.Хувь хүний ур чадвар нэмэгдүүлэх сургалтын хамрагдсан иргэдийн тандалт судалгааг орон нутгийн байгууллагатай хамтран 3 жил тутамд нэг удаа хийж мэдээллийн сан бүрдүүлнэ.</p> <p>2.Хувь хүний ур чадвар нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p> <p>3.Сургалт, нөлөөллийн арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.</p> <p>4.Холбогдох мэдээ тайланг үр дүнд суурилсан байдлаар цаг хугацаанд нь тайлагнана.</p> <p>5.Төвийн дотоод ажил болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>
1.4	Цахим ур чадвар хариуцсан сургалтын менежер	Насан туршийн суралцахуйн талаар контент хийх, төвийн үйл ажиллагааг иргэдэд суртчилах, иргэдийн цахим мэдлэг, технологийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалт нөлөөллийг ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, судалгааг хийх	<p>1.Насан туршийн суралцахуйн чиглэлээр иргэдэд цахим контент, танилцуулга бэлтгэх, түгээх үйл ажиллагааг зохион байгуулах ба мэргэжлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.</p> <p>2.Төвд суралцаж буй иргэдийн бүртгэл, мэдээллийг боловсролын удирдлага мэдээллийн системд бүртгэн холбогдох тайлан мэдээг гаргана.</p> <p>3.Иргэдийн цахим ур чадварын судалгааг орон нутгийн байгууллагатай хамтран 3 жил тутамд нэг удаа хийж мэдээллийн сан бүрдүүлэх</p> <p>4.Холбогдох мэдээ тайланг үр дүнд суурилсан байдлаар цаг хугацаанд нь тайлагнана.</p> <p>5.Төвийн дотоод ажил болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>
1.5	Амьдрах ухааны ур чадвар хариуцсан сургалтын менежер	Иргэдийн ажил амьдралын орчноос үүсэж буй амьдрах ухааны мэдлэг чадварын судалгааг гаргах, иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн орон нутгийн холбогдох байгууллагатай хамтран ажиллаж мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх	<p>1.Иргэдийн ажил, амьдралын орчноос үүссэн ур чадварын судалгааг орон нутгийн байгууллагатай хамтран 3 жил тутамд нэг удаа хийж мэдээллийн сан бүрдүүлэх</p> <p>2.Иргэдэд ур чадвар олгох сургалт, нөлөөллийн ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.</p> <p>3.Ур чадвар эзэмшсэн иргэдийн бүртгэлийг хийх, иргэдийн бүтээлээр үзэсгэлэн гаргах талаар бусад байгууллагатай хамтран ажиллана.</p> <p>4.Холбогдох мэдээ тайланг үр дүнд суурилсан байдлаар цаг хугацаанд нь тайлагнана.</p>

			5.Төвийн дотоод ажил болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.
2	<b>Албан бус боловсролын багш</b>	Орон нутгийн ялгаатай хэрэгцээтэй иргэдийг боловсролд хамруулах, монгол хэл, бичиг/ гадаад хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх, цахим ур чадварт суурилсан цаг хугацаа, орон зайг үл хамааран суралцахад дэмжлэг үзүүлж, сургалтын агуулга, төлөвлөгөө боловсруулах, боловсролын сургалтын байгууллагатай хамтран ажиллах	1.Иргэдийн монгол хэл, бичиг/ гадаад хэлний мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, сургалтын агуулга, төлөвлөгөө боловсруулах, холбогдох боловсролын сургалтын байгууллагын багштай хамтран ажиллана. 2.Иргэдийн цахим боловсрол, технологийн ур чадвар, мэдлэгийг нэмэгдүүлэх, сургалтын агуулга, төлөвлөгөө боловсруулах холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. 3.Тухайн орон нутгийн ялгаатай хэрэгцээтэй иргэдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах сургалтын төлөвлөгөө агуулга, боловсруулах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэдийн боловсрол хамрагдалтыг нэмэгдүүлнэ. 4.Холбогдох мэдээ тайланг үр дүнд суурилсан байдлаар цаг хугацаанд нь тайлагнана. 5.Төвийн дотоод ажил болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тайлбар:

Орон тооны жишиг хязгаарын нормативд батлагдсан сургалтын менежерийн албан тушаалыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 1 менежерэй бол 1.1; 3 менежертэй бол 1.1, 1.2, 1.3; 4 менежертэй бол 1.1, 1.2, 1.3, 1.4; 5 менежертэй бол 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5-д заасан менежер, 6 болон түүнээс дээш менежертэй бол 1.2, 1.3, 1.4, 1.5-аас тухайн төвийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч тус тус нэмэгдүүлж болно.

Орон тооны жишиг хязгаарын нормативд батлагдсан албан бус боловсролын багш 2 байвал Монгол хэл, бичиг/ Гадаад хэлний багш, Цахим боловсролын багш, 3 бол Монгол хэл, бичиг/ Гадаад хэлний багш, Цахим боловсролын багш, Тэгш хамруулах боловсролын багш, 5 болон түүнээс дээш бол Монгол хэл, бичиг/ Гадаад хэлний багш, Цахим боловсролын багш, тэгш хамруулах боловсролын багшийг тухайн төвийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч тус тус нэмэгдүүлж болно.

Аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн захирал албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулахдаа энэхүү зорилго, зорилттой уялдуулан боловсруулж баталгаажуулна.